



Дэлхийн Шатрын Холбооноос зохион байгуулж буй Өсвөрийн Шатарчдын Дэлхийн Аварга шалгаруулах тэмцээн 2017

1. Урилга

Дэлхийн Шатрын Холбоо, Америкийн Шатрын Нэгдсэн Холбоо, Бразилийн Шатрын Холбоо, Миназ Жерайс мужийн Шатрын Холбоо, ДХШАШТ-ий 2017 оны зохион байгуулах хороо болон ивээн тэтгэгч байгууллагууд Дэлхийн Шатрын Холбооны салбар бүх Шатрын Холбоодыг Бразил улсын Poços de Caldas хотноо 2017 оны 08 сарын 21-нээс 2017 оны 08 сарын 31-ний өдрийг хүртэл үргэлжлэх “**Дэлхийн Шатрын Холбооноос зохион байгуулж буй Өсвөрийн Шатарчдын Дэлхийн аварга шалгаруулах тэмцээн 2017**”-д оролцохыг урьж байна.

2. Оролцох

- 2.1. Холбоо тус бүр нэг хүнийг 8-аас доош 10-аас доош, 12-оос доош насны ангилалд (эрэгтэй, эмэгтэй төрөлд) албан ёсны тоглогчоор тус тус оролцуулж болно. Тоглогчид оролцож буй насныхаа ангилалд 2017 оны 01 сарын 01-ний байдлаар хүрээгүй байх ёстой.
- 2.2. Өмнөх дэлхийн аваргад оролцон, эхний 3-н байранд багтсан хүүхдүүдийг албан ёсны тоглогчоор тооцох ба өөрийн нас, эсвэл дээд насныхаа ангилалд оролцож болно.
- 2.3. Албан ёсны тоглогчоос бусад тоглогчдыг нэмэлт тоглогчдоор тооцно. Тухайн улсын шатрын холбоо хэдэн ч нэмэлт тоглогчийг бүртгүүлж болно.

3. Тэмцээний хураамж

3.1. Албан ёсны тоглогчид 70 евро, нэмэлт тоглогчид 140 еврог тэмцээнээс өмнө төлөх ёстой.

3.2. Төлбөрийг өөрийн улсын Шатрын Холбоогоор дамжуулан шилжүүлнэ.

Монголын Шатрын Холбоо еврогийн данс: 1105108160 Голомт банк

Харилцах утас: 70111880

4. Бүртгэл

- 4.1. Бүх тоглогчид болон дагалдан яваа хүмүүс бүртгэлийн хураамж 100 еврог 2017 оны 06 сарын 20-ноос өмнө өөрийн орны шатрын холбоогоор дамжуулан төлнө. Үүн дээр МШХ-ны хураамж болох 15\$, дагалдан явах хүмүүс 20\$-ийг дээр заасан хугацаанд шилжүүлнэ.
Монголын Шатрын Холбооны еврогийн данс: 1105108160 Голомт банк
Монголын Шатрын Холбооны долларын данс: 1105043303 Голомт банк
- 4.2. Бүртгэл хоцорсон тохиолдолд 100 евроны торгууль төлөх ба 2017 оны 08 сарын 10-наас хойш дахин бүртгэхгүй.
- 4.3. Оролцогчид 2017 оны 06 сарын 20-ны өдрөөс өмнө паспортын хуулбар, 2*3 хэмжээтэй цээж зургийн хамт илгээх ёстой.
Цахим шуудан: Pressmcf@gmail.com
- 4.4. Бүртгэлийн хураамж болон бусад хураамжийг буцаан олгохгүй.

5. Аялал

- 5.1. Тэмцээнийг Голден Парк зочид буудлын Хурлын төвд зохион байгуулна.
- 5.2. Тэмцээн болох газар нь Thermas World Resort-оос 160 метр, Golden Park зочид буудлаас 160 метр, Village Inn зочид буудлаас 120 метрийн зайтай.
- 5.3. Оролцогчид аяллын мэдээллээ 2017 оны 07 сарын 20-ны өдрөөс өмнө аяллын мэдээллээ ирүүлнэ.

6. Зочид буудлууд

- 6.1. Thermas Resort Walter World, 4-н одтой, өдрийн 3 хоолтой
Triple room: нэг хүний 75 евро
Double room: нэг хүний 77 евро
Single room: нэг хүний 130 евро

Thermas Resort Walter World, 4-н одтой, өглөөний цайтай
Triple room: нэг хүний 65 евро
Double room: нэг хүний 67 евро
Single room: нэг хүний 120 евро
- 6.2. Golden Park, 4-н одтой, өдрийн 3 хоолтой
Triple room: нэг хүний 73 евро
Double room: нэг хүний 75 евро
Single room: нэг хүний 120 евро

Golden Park, 4-н одтой, өглөөний цайтай
Triple room: нэг хүний 63 евро
Double room: нэг хүний 65 евро
Single room: нэг хүний 110 евро

- 6.3. Village Inn, 3-н одтой, өглөөний цайтай
Triple room: нэг хүний 50 евро
Double room: нэг хүний 52 евро
Single room: нэг хүний 90 евро

7. Тоглолтын Дүрэм

- 7.1. Дэлхийн Шатрын Холбооны журмыг баримтлан Швейцарь системээр 11 өрөг тоглоно.
- 7.2. Цагийн хяналт: эхний 40 нүүдэл 90 минут + 30 минут, нүүдэл бүрт 30 секундын нэмэлттэй
- 7.3. Оноо тэнцсэн тохиолдолд:
1. Хоорондын хожил
 2. Buchholtz- Cut 1
 3. Buchholtz
 4. Хараар тоглосон тоо
 5. Нийт хожил

8. Цагийн хуваарь

08 сарын 21		Хүрэлцэн ирэх
08 сарын 21		Техникийн зөвлөгөөн
08 сарын 22	15:30	Нээлтийн үйл ажиллагаа
08 сарын 22	16:00	1-р өрөг
08 сарын 23	10:00	2-р өрөг
08 сарын 23	17:00	3-р өрөг
08 сарын 24	15:00	4-р өрөг
08 сарын 25	15:00	5-р өрөг
08 сарын 26		Чөлөөт өдөр
08 сарын 27	15:00	6-р өрөг
08 сарын 28	10:00	7-р өрөг
08 сарын 28	17:00	8-р өрөг
08 сарын 29	15:00	9-р өрөг
08 сарын 30	15:00	10-р өрөг
08 сарын 31	09:00	11-р өрөг
08 сарын 31	14:30	Хаалтын үйл ажиллагаа
08 сарын 31	16:00	Үдэлт

9. Шагнал

- 9.1. Бүх төрлөөс хамгийн олон медальтай холбоо цомын эзэн болно. Ялагчийг тодруулахдаа алтан медалийн тоог урьтал үнэлгээ болгож, оноо тэнцвэл мөнгө, хүрэл медалийн тоог харьцуулна.
- 9.2. Бүх ангиллын эхний 3-н байр цом болон медаль хүртэнэ.
- 9.3. Харин 4,5,6-р байрууд медалийн эзэд болцгооно.